



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№163
/377/

2022.09.14

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН ӨВӨЛ СУРГУУЛИЙН БЭЛТГЭЛТЭЙ ТАНИЛЦАЖ БАЙНА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатараар ахлуулсан ажлын хэсэг БХЯ-ны харьяа байгууллагуудын 2022-2023 оны өвөл сургуулийн бэлтгэлтэй танилцах ажил эхэллээ.

Ажлын хэсэг удирдамжийн дагуу өнөөдөр Цэргийн төв эмнэлэг, Батлан хамгаалахын Эмгэг судлал, шүүх эмнэлэг, "Барилга захиалагчийн алба" ТӨААТҮГ-ын үйл ажиллагаа, өвөл сургуулийн бэлтгэлжилтийг хэрхэн хангаж байгаа үйл ажиллагааны явцтай танилцсан юм.

Энэхүү ажлын салхийг хагалсан Цэргийн төв эмнэлэгийн дарга хурандаа Б.Энх-Од байгууллагынхаа үйл ажиллагааны өнөөгийн байдал болон цаашдын хөгжлийн чиг хандлага,

тулгамдаж буй асуудлын талаар илтгэл хийсэн бөгөөд ажлын хэсгийнхэн тус эмнэлгийн хэлтэс, албад, эмчилгээний өрөө тасалгаагаар орж, үйл ажиллагааны талаар асууж тодруулахын зэрэгцээ үйлчлүүлэгчидтэй ярилцаж, санал сэтгэгдлийг нь сонслоо.

Монгол Улсын Засгийн газрын Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын хэрэгжилт, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх зөвлөлийн үйл ажиллагаа, Батлан хамгаалахын сайдын өвөлжилтийн бэлтгэлийг хангах, ажлын байрны эрүүл ахуй, халдваргүйтгэл, ариутгалын байдалтай танилцаж, цаашид

тулгамдаж буй асуудалд үнэлэлт дүгнэлт өгөх үндсэн зорилготой өвөл сургуулийн бэлтгэлтэй танилцах ажил долоо хоногийн хугацаанд үргэлжлэх бөгөөд БХЯ-ны харьяа 12 байгууллага хамрагдана.

Ажлын хэсэг байгууллагуудын өвөл сургуулийн бэлтгэл ажлын үр дүнгээр тайлан бичиж, Батлан хамгаалахын сайдын зөвлөлд танилцуулна. Үүний дараа ЗХЖШ-ын хугацаат цэргийн алба хаагчидтай нэгтгэл, анги байгууллагуудад ажиллаж, өвөлжилтийн бэлтгэл ажил, хангалтын үйл явцтай танилцах юм байна.

Х.УНДАРМАА

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 24	🌧️ 6

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 30	🌧️ 23

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.300	3.310
EUR 🇪🇺	3.385	3.410
CNY 🇨🇳	478	482
RUB 🇷🇺	51.20	52
JPY 🇯🇵	23.70	24.35
KRW 🇰🇷	2.40	2.41

ЗУРХАЙ

2022.09.14 /ЛХАГВА ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 19

НАМРЫН ТЭРГҮҮН ШАР БИЧ
САРЫН
ДОЛООН УЛААН ЦАГААН
МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:
Сайн нөхөртэй нөхөрлөнө.
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
06.28-19.08
Барилдлага:
Үхэх
Шүтэн барилдлага:
Төрөн түгэхүй

Тухайн өдөр бар, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зерэг сайн. Могой, морь жилтнээ сөрөг нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж биеэ энхрүүлүүштэй.

Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан гөрөө хийх, мал адгуус муулах, гаригийг тахиж, тангараг тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийх, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, хүүхэд хөлд оруулахад муу.

Хол газар яваар одогсод хойд зүгт мөрөө гаргавал зохистой.

КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 614,714,581

Эдгэрсэн

Нийт: 593,820,007

Нас барсан

Нийт: 6,520,506

ШИНЭ БҮТЭЭЛИЙНХЭЭ ДЭЭЖИЙГ ӨРГӨН БАРИЛАА



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтдийн хамтын бүтээл болох "Мэдээллийн дайн, түүний стратеги, тактик" номыг танилцуулах, түүний дээжийг Зэвсэгт хүчний удирдах албан тушаалтнуудад өргөн барих ёслолын ажиллагааг энэ сарын 14-ний өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын хуралдааны танхимд зохион байгуулав.

Ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын сайдын зөвлөл бэлтгэл дэслэгч генерал Ц.Дашзэвэг, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга бригадын генерал С.Ганбямба, БСТГ-ын дарга бригадын генерал Ц.Гандорж, Сургалт, бэлтгэлийн газрын даргын орлогч, Сургалтын бодлогын хэлтсийн дарга хурандаа Д.Жигжидсүрэн, Холбоо, мэдээллийн технологийн хэлтсийн дарга хурандаа М.Золзааяа, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн

командлагч бригадын генерал Д.Баасандамба, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, доктор, профессор, хурандаа Б.Эрдэнэбат болон БХЭШХ-ийн төвийн дарга нар, эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтнууд оролцлоо.

Энэ үеэр уг судалгааны бүтээлийн зохиогчдыг төлөөлж, БХЭШХ-ийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, чөлөөнд байгаа хурандаа Ш.Паламдорж Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дэслэгч генерал Д.Ганзориг болон Зэвсэгт хүчний зарим удирдах албан тушаалтанд уг номынхоо дээжийг өргөн бариллаа.

Энэхүү номын эхэнд редактор, профессор Ц.Дашзэвэг бичихдээ "Мэдээллийн дайн, түүний стратеги, тактик" гэсэн энэхүү нэг сэдэвт, онол, практикийг шинжилгээ бүхий хамтын бүтээл нь эрин

зууны мэдээлэл, мэдээллийн технологийн хөгжил, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улсын суурь дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн нөхцөл байдалтай холбоотой бөгөөд мэдээллийн технологийг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага, "хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлэн хөгжүүлэх" үндэсний хөгжлийн урт хугацааны бодлогод дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн болно. Улс, нийгэм, эдийн засаг, улсын суурь дэд бүтцийг хамгаалах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, мэдээллийн аюулаас сэрэмжлэх арга замыг тайлбарласнаараа иргэдэд, дайны стратеги, тактикийг довтолгоо, хамгаалалт талаас нь авч үзсэнээрээ цэргийнхэнд зориулсан бүтээл юм" гэдгийг онцолсон байна. Уг номын эрхэм зохиогчдод талархсанаа илэрхийлж, цаашдын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд арвин их амжилтыг бэлгэдэн ерөөе.

Хурандаа Б.ОТГОНБЯАР

ЦАХИМ ШУУДАНД

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АНГИ, САЛБАРУУД "ТОХИЖИЛТТОЙ ХАШАА" АЯНД НЭГДЭЖ БАЙНА



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 340 ДҮГЭЭР АНГИ

Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газраас зохион байгуулж буй "Жишиг тохижилттой хашаа байгуулах" арга хэмжээний хүрээнд гэр хороололд амьдардаг алба хаагчдын эрүүл, аюулгүй, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, ахуйн амьдралыг дэмжих зорилгоор Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн Ахлах ахлагч Н.Төмөрбаатарын өмчийн 0.5га хашааг ангийн захирагчийн тушаалаар томилогдсон бие бүрэлдэхүүн тогтоосон хугацаанд үр дүнтэй хийж гүйцэтгэлээ.

Уг ажлын хүрээнд: Хашааны өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор хашааг бүрэн шинэчилж, явган хүний зам, гэрэлтүүлэг, машины зогсоол,

стандартад нийцсэн бие засах газар, хогийн цэг, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл аюулгүй тоглох орчныг бүрдүүлэх зорилгоор хүүхдийн тоглоомын талбай, элсний хайрцаг, сагсны шийд, амрах сүүдрэвч, турник, хашаанд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, ая тухтай амьдрах орчин бүрдүүлэх зорилгоор Улиас-12 ширхэг, бургас-15 ширхэг, шар хуайс-20 ширхэгийг шинээр суулгаж, хүнсний нарийн ногоо тарих боломжтой 4x4 харьцаатай хүлэмж зэрэг бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэв.

Сэтгэл зүйн хангалтын офицер
Д. Уянгаа

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 338 ДУГААР АНГИ

Зэвсэгт хүчний 338 дугаар анги нь Зэвсэгт хүчний барилга инженерийн цэргийн удирдах газрын даргын "Жишиг тохижилттой хашаа байгуулах ажлыг зохион байгуулж явуулах" тухай тушаалын дагуу хамт олны хурлаар хэлэлцэн нийт бүрэлдэхүүний саналаар барилга угсралт, засварын ротын нэгдүгээр салааны засал чимэглэлийн тасгийн засал чимэглэлчин, ахлагч Ч.Мөнхцэцэгийг сонгон өөрийнх нь хувийн эзэмшлийн хашааг тохижуулах ажлыг гүйцэтгэв.

Тохижилтын ажлуудыг гүйцэтгэхэд томилогдсон ажлын бүлгийн бүрэлдэхүүн мэргэжлийн ур чадвар гарган ажиллаж, хамт олны зүгээс зарим ажилд туслалцаа дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ эмэгтэйчүүдийн зөвлөлөөс өдрийн цагаар хоол, цай бэлтгэх ажилд оролцож уг ажил нь хамт олны эерэг уур амьсгалыг бүрдүүлж алба хаагчийнхаа нийгмийн хамгаалалд дэмжлэг үзүүлсэн томоохон ажил болон өрнөлөө.

Дэслэгч Б.Пүрэвлхам

ГЭРЭЭТ ЦЭРЭГ-ГЭРЭЛТЭЙ АЛБА



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги 2021 онд хугацаат цэргийн албанд татагдан ирсэн дайчдаас албаа үлгэр жишээчээр хааж, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангид цэргийн гэрээт албанд өөрийн хүсэлтээр улиран үлдэж буй түрүүч, байлдагч нарыг цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халах, ангийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын

ажиллагааг зохион байгууллаа. Ёслолын үйл ажиллагаанд ангийн нийт бие бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний 331 дүгээр ангийн цэргийн гэрээт албан хаагчдыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүн, халагдаж буй цэргийн алба хаагчдын гэр бүлийн төлөөлөл оролцлоо.

Үйл ажиллагааны үеэр

Дэд түрүүч "Онц буудагч", Г.Лхагвадоржийг сурлагатан", байлдагч Ө.Лхагвадорж, Ж.Нямбат нарын гэр бүлд талархлын захидал хүрүүлэхийн зэрэгцээ алба хаагч тус бүрд дурсамж цомог, цэргийн албанд байх хугацаанд хийсэн ажлын хөлс, төмөр замын бүтээн байгуулалтад

Б.Доржбатыг байлдагч "Онц байлдагч Шагнал авсан түрүүч Шангал авсан түрүүч нарт ангийн үлээвэр найрал хөгжимчдийн бие бүрэлдэхүүн урлагийн тоглолтоо толилуулав.

Мөн энэхүү ёслолын ажиллагааны үеэр Эх орноо батлан хамгаалах, Улс эх оролцсон ажлын цалин зэргийг хийсэн хадгаламжийн дэвтрийг гардуулан өглөө.

орныхоо бүтээн байгуулалтад өөрийн хувь нэмрээ оруулах үүргээ амжилтай биелүүлж цэргийн гэрээт албанд томилогдсон түрүүч, байлдагчдыг төлөөлж дэд түрүүч Б.Доржбат үг хэлсэн юм.

Сэтгэл зүйн хангалтын офицер Д.Уянгаа